

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2026 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, Мягмар гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-7
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	8-26
<hr/>	
1.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	8-9
2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Энхтүвшин, Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/	9-13
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	13-14
4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/	14-15
5.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайлан	15-26

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
06 дугаар сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Б.Баярбаатар, Т.Доржханд, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Б.Хэрлэн, О.Цогтгэрэл, Ө.Шижир, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Б.Пүрэвдорж.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Болормаа, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

**Б.Жавхлан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 13 гишүүнээс 2026.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 21 гишүүнээс 2026.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Засгийн газраас 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Засгийн газраас 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын Засгийн газраас 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 14 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Энхтүвшин, Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал нараас өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Болормаа, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

*Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Жавхлан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Ц.Баатархүү, Б.Батбаатар, Ж.Ганбаатар, Д.Ганмаа, Ц.Даваасүрэн, Б.Жаргалан, С.Зулпхар, Н.Наранбаатар, Э.Одбаяр, А.Ундраа, Ч.Ундрам, Г.Уянгахишиг, Ө.Шижир, Л.Энх-Амгалан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.5.Гишүүн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн гишүүний баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг энэ хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хамтран санаачилсан бол төлөөлөх” гэсний дараа “нэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “асуулт асуусан, үг хэлсэн тоо” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “болон хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7  
Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.7.2.а гэсэн дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.7.2.г гэсэн дэд заалт, 8.11 дэх хэсгийг тус тус хасаж, төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 12  
Бүгд: 17  
29.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Ажлын хэсгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5, 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн зүүн гар талд олонхын бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд олонхын бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас олонхын бүлгийн бусад гишүүдийг суудлын хуваарилна.

15.6.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд тус бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас цөөнхийн бүлгийн бусад гишүүдийн суудлыг хуваарилна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 6  
Бүгд: 17  
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3.15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 7

Бүгд: 17  
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Байнгын хорооны дарга Б.Жавхлан ажлын 1 өдрийн завсарлага өгөв./15:21/

***Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Болормаа, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах шаардлагагүй гэсэн горимын санал гаргав.

**Б.Жавхлан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 10  
Бүгд: 17  
41.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Жавхлан:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17  
52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Жавхлан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 8  
Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

*Уг асуудлыг 15 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Болормаа, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Жавхлан “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Жавхлан:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 15 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайлан***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, мөн хорооны гишүүн Л.Цэдэвсүрэн, Л.Золзаяа, Б.Пүрэвдагва, Б.Төгсцэнгэл, Ш.Батсүх, Д.Дуламсүрэн, М.Цэрэнбат, Ч.Эрдэнэчимэг, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, мөн Ажлын албаны Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга Б.Нарангарав, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Батнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Болормаа, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, С.Зулпхар, Б.Жавхлан нарын тавьсан асуултад Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг хэлэлцэв.

*Уг асуудлыг 16 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 25 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЖАВХЛАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 06 дугаар сарын 16-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
14 цаг 45 минут.

### **ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Жавхлан:** Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 16-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хороо /ТББХ/-ны ээлжит хуралдаанаа эхлүүлье. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ТББХ-ны хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурал /УИХ/-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя Оюунсайханы Алтангэрэл, Жигжидийн Батжаргал, Сандагийн Бямбацогт, Сархадын Зулпхар, Эрдэнэбилэгийн Одбаяр, Баттогтохын Чойжилсүрэн, Аюушийн Ариунзаяа, Жудагийн Баярмаа, Лувсаннъямын Гантөмөр, Бадрахын Найдалаа, Чинбатын Ундрэм, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Бат-Эрдэнэ, Энхбатын Болормаа, Болдын Жавхлан, Нямтайширын Номтойбаяр, Ням-Осорын Учрал гишүүд хуралдааныхаа ирцэд ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1. УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал. 2. Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл УИХ-ын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Дашцэрэнгийн Энхтүвшин, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Хүрэлбаатарын Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг. 3. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 4. Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. 5. Байнгын хорооны тогтоол Ажлын хэсэг байгуулах тухай. 6. Байнгын хорооны тогтоол Ажлын хэсэг байгуулах тухай. 7. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайлан.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Монгол УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцэх эсэх асуудал. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан ТББХ-ны хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан. УИХ-д өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад гишүүд бэлэн болсон байна.

Санал хураалт 1. УИХ-ын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн нарын 13 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт, сая тогшчихсон шүү. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 41.2 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт 2. УИХ-ын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 21 гишүүн 2026 оны 6 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 41.2 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

Санал хураалт 3. ЗГ 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар уг санал дэмжигдлээ.

Санал хураалт 4. ЗГ 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар уг санал дэмжигдлээ.

Санал хураалт 5. ЗГ-ын 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар уг санал дэмжигдлээ.

14.53 цаг

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын***

***төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Д.Энхтүвшин, Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал нараас өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэх асуудал 2. УИХ-ын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ, Дашцэрэнгийн Энхтүвшин, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Хүрэлбаатарын Баасанжаргал нарын гишүүд өргөн мэдүүлсэн Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тухай нэгтгэсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Монгол УИХ-ын даргын 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 232 дугаар захирамжаар Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан байгаа. Ажлын хэсгийн танилцуулгыг уншиж танилцуулья.

Монгол УИХ-ын даргын 232 дугаар захирамжаар байгуулагдсан Монгол УИХ-ын тухай хууль, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Б.Жавхлан миний бие ахалж, бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн Баатархүү, Батбаатар, Ганбаатар, Ганмаа, Даваасүрэн, Жаргалан, Зулпхар, Наранбаатар, Одбаяр, Ундраа, Ундрам, Уянгахишиг, Шижир, Энх-Амгалан нар ажиллалаа.

Ажлын хэсэг нийт 4 удаа хуралдсан бөгөөд анхны хуралдаанаараа хууль санаачлагчдаас өргөн мэдүүлсэн төслүүдийг нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсний дагуу Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг нэгтгэн та бүхэнд тараасан болно. Ажлын хэсэг гишүүдийн саналыг 7 хоногийн турш авч, Байнгын хорооны хуралдаанаар Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ажлын хэсэг УИХ-ын гишүүдээс гаргасан болон ажлын хэсгийн боловсруулсан нийт 41 зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд тараасан болно. УИХ-ын гишүүн Энхтүвшин ажлын хэсгийн хуралдаанаар дэмжигдээгүй зарчмын зөрүүтэй саналаа эргүүлэн татсан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, ажлын хэсэг болон УИХ-ын гишүүдээс ирүүлсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Нэг.Монгол УИХ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Гишүүд анхааралтай байгаарай. 1 дүгээр зүйлтэй холбоотой саналууд.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.5.Гишүүн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн гишүүний баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг энэ хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд

нийцүүлэн Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр тогтооно.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Жавхлан, Баатархүү, Батбаатар, Ганбаатар, Ганмаа, Даваасүрэн, Жаргалан, Зулпхар, Наранбаатар, Одбаяр, Ундраа, Ундрэм, Уянгахишиг, Шижир, Энх-Амгалан. Цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. санал хураалтад 17 гишүүн оролцож 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар уг санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “хамтран санаачилсан бол төлөөлөх” гэсний дараа “нэг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар уг санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “асуулт асуусан, үг хэлсэн тоо” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, УИХ-ын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар уг санал дэмжигдлээ.

4.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийн “болон хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар уг санал дэмжигдлээ.

5.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.7.2.а гэсэн дэд заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар уг санал дэмжигдлээ.

6.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 8 дугаар зүйлийн 8.7.2.г гэсэн дэд заалт, 8.11 дэх хэсгийг тус тус хасаж, төслийн дугаарыг өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 5 гишүүн дэмжиж, 29.4 хувиар уг санал дэмжигдсэнгүй.

7.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5, 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.5.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн зүүн гар талд олонхын бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд олонхын бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас олонхын бүлгийн бусад гишүүдийг суудлын хуваарилна.

15.6.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд тус бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас цөөнхийн бүлгийн дарга, Улсын Их Хуралд суудалтай бусад намын дарга болон цөөнхийн бүлгийн бусад гишүүдийн сандлыг хуваарилна.” Санал гаргасан ажлын хэсэг, УИХ-ын гишүүн Тэмүүжин. Тийм, тийм. Тэмүүжин гишүүний тийм санал байсан шүү та нар энийг саяын техникийн алдаа гаргасан байна шүү. Энийг 15.6-г нь дахиад уншлаа. Анхааралтай байгаарай гишүүд.

Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан, бүлгийн гишүүдийн суудал, уучлаарай, дахиад уншлаа.

15.6.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд тус бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас Улсын Их Хуралд суудалтай бусад намын дарга болон цөөнхийн бүлгийн бусад гишүүдийн суудлыг хуваарилна.” Редакц хараадхаарай. Одоо байгаа суудалд өөрчлөлт орохгүй. Ажлын хэсэг дээр санал хураагдсан асуудал шүү. Тийм учраас энд уншиж танилцуулна. Энэ найруулга дээр редакцын алдаа гарсан байна шүү. Гишүүдээс хүлцэл өчье. Энэ одоо яг зөв нь болох гээд байна шүү. Гишүүд анхааралтай байгаарай.

15.6.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн зүүн гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд, уучлаарай энэ чинь баруун баруунаар нь унших юм байна. Баруун уучлаарай тэгвэл дахиад дахиад засаж унших юм байна. 15.6.Нэгдсэн хуралдааны танхимд хуралдаан даргалагчийн баруун гар талд хамгийн олон суудал авсан цөөнхийн бүлгийн гишүүдийн суудал байх бөгөөд нүүрний эгнээнд тус бүлгээс сонгогдсон Улсын Их Хурлын дэд даргын суудлын дараагаас цөөнхийн бүлгийн бусад гишүүдийн суудлыг хуваарилна. Санал гаргасан ажлын хэсэг, УИХ-ын гишүүн Тэмүүжин. Санал хураалт. Болж байгаа, болж байгаа. 17 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар уг санал дэмжигдлээ.

8.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн, саяын санал хураалт дээр үү? Сая санал хураалт явчихсан шүү дээ. Батжаргал гишүүний микрофоныг.

**Ж.Батжаргал:** Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. УИХ-ын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслүүдийг уншиж үзээд, 15 дугаар зүйл дээр санал байгаад байгаа юм. 15.5, 6-аагаа өөрчлөн найруулаад сая зарчмын зөрүүтэй саналын томьёолол нь дэмжигдчихлээ. Гэтэл яг энэ харилцааных нь суурь болсон 15.4 нь хөндөгдөхгүй орж ирчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг миний Байнгын хороонд ирүүлсэн зарчмын зөрүүтэй санал 2026 оны 6 сарын 10-ны өдөр өгсөн санал бол нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 15.4, 7-г хасахаар ийм санал зарчмын зөрүүтэй санал оруулсан юм. Наана чинь юу нь байгаа биз дээ? Зарчмын зөрүүтэй санал оччихсон байгаа.

Тэгэхээр би өнөө зүйлээр явж байгаа учраас зүйл дотроо, юу нь бүлгээр явж байгаа учраас зүйлүүд дээрээ хөөгдөнө гэж ойлгоод санал гаргаад байна шүү дээ би. 15.4-ийг хасах. Хурлын танхимын хоймор хэсэгт зөвхөн Их Хурлын даргын суудал байна гэсэн үг байгаад байгаа байхгүй юу. Энийг хасахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Юу гэсэн үг юм, энэ дээр хэн ч тохироогүй, ямар, хэн тохирсон юм? Үгүй ээ үгүй. Та нар зарчмын зөрүүтэй саналуудаараа, үгүй ээ, үгүй, 15.4 байхгүй гэдгээ тохирсон биз дээ. Та 15.4 байхгүй гэж тохироо биз дээ энэ чинь. Үгүй ээ та хэд чинь тэгээд одоо тэр УИХ-ын гишүүн Ерөнхий сайд байвал одоогийн суудалдаа байна гэж хэлсэн юм байна лээ шүү дээ. Тэгж тохирсон юм байна лээ шүү дээ. УИХ-ын гишүүн биш Ерөнхий сайд байвал суудал нь өөр байя гэж тохирсон юм байна лээ шүү дээ. Тэгвэл зүгээр УИХ-ын гишүүн биш Ерөнхий сайдыг л заалтаар нь ангилж, тэр та хэдийн тохирсон заалт орно. Их Хурлын гишүүн Ерөнхий сайд байвал одоогийнхоороо байх ёстой байхгүй юу. Тийм учраас энэ 15.4-ийг авахгүй бол зөвхөн Их Хурлын дарга хурал даргалагч гэсэн үг байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хөдөлнө л гэсэн үг шүү дээ наад суудал чинь. Та хэд чинь тэгж тохирсон юм байна лээ шүү дээ. Та хэд тэгж тохирсон юм байна лээ шүү дээ.

Харин та тэгж болохгүй шүү дээ. Та хэд чинь хоорондоо ажлын хэсэг дээрээ яриад, УИХ-ын гишүүн бус Ерөнхий сайд байвал өөр суудалд сууя гэдгийг та хэд тохироод оруулсан юм байна лээ шүү дээ. Тэгэхээр зэрэг УИХ-ын гишүүн Ерөнхий сайд нь одоогийнхоо суудлаар байна гэдгээ, харин тэгээд орхих гэхээр зэрэг наадах чинь хурлын хойморт ганцхан, энэ чинь байгаад байна шүү дээ хурлын хойморт гээд наад 15.4 чинь таны оруулж ирсэн. Харин тэгээд энийг хасах ёстой шүү дээ. Одоо суудал дээрээ сууна шүү дээ.

**Б.Жавхлан:** Батжаргал гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан учраас саяын Батжаргал гишүүний гаргасны дагуу УИХ-ын 15-ын өргөн барьсан хууль энд, УИХ-ын тухай хуулийн нэгтгэсэн төслийн 3.15 дугаар зүйлийн 15.4-ийг бүхэлд нь хасья гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар уг санал дэмжигдлээ. Тэмүүжин гишүүн үг хэлье гэж байна. Тэмүүжин гишүүний микрофон.

**Х.Тэмүүжин:** Ардчилсан нам /АН/-ын бүлгээс хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад 5 өдрийн завсарлага авч байна.

15.18 цаг

**Б.Жавхлан:** Гишүүний гаргасан саналаар нэг хоногийн завсарлага. Дараагийн асуудал, дараагийн асуудал руугаа орно шүү. Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудал дээр АН-аас нэг хоногийн завсарлага авсан тул хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой 2, 3 дугаар асуудлыг мөн хэлэлцэх боломжгүй болж байна. Тийм учраас 4 дүгээр асуудал руугаа ороод хуралдаанаа үргэлжлүүлье. 5 юм байна шүү.

### *Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/*

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж эхэлье. ЗГ-аас 2026 оны 5 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тогтоолын төслийг боловсруулсан байгаа. Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Тогтоолын төсөл нь хаана байна вэ, яагаад? Батжаргал гишүүн горимын санал гаргая гэж байна. Микрофоныг өгье.

**Ж.Батжаргал:** ЗГ-аас өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлт дээр ажлын хэсэг байгуулах шаардлагагүй юм байна лээ. Би ЗГ-ын холбогдох энэ асуудлаа хариуцсан улсуудтай нь уулзаж санал бодол сонссон. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлээд явъя гэхээр зэрэг бэлтгэл ажлууд нь хангагдаж яваад энэ он дуусна. Ирэх онд хэрэгжүүлье гэхээр зэрэг Ерөнхийлөгчийн сонгуультай жил засаг, захиргаа элдэв бусын юманд өөрчлөлт хийх боломжгүй. 28 онд дахиад УИХ-ын болоод орон нутгийн сонгуультай, дахиад засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид өөрчлөлт хийх боломжгүй.

Тийм учраас ЗГ 2029 оны 1 сарын 1-нээс мөрдүүлэхээр хойшлуулъя гэсэн ийм саналтай явж байтал ЗГ-ын зарим гишүүд энэ 2 хотыг тэргүүн ээлжид энэ хотынх нь статус руу дүүргийг Налайх, Багануур 2-ыг шилжүүлчихье гэсэн ийм санал

гарч ирээд, тэр нь яваад ороод ирчихсэн юм байна лээ. Одоо энэ дээр ажлын хэсэг яаж ч байгуулагдаж, яаж ч суугаад цаг алдахын нэмэр, ямарваа нэгэн шийдэл гаргах боломжгүй. Тийм учраас би ерөөсөө энэ дээр ажлын хэсэг байгуулах хэрэггүй. Тэр хэлэлцүүлэг хоорондынх нь хугацаа болж байгаа бол шууд юу руугаа оръё. Миний завсарлага авсан хугацаа дуусангуут тэгээд л хэлэлцэх эсэхийг нь дэмжих эсэх асуудлаараа шууд явах нь зөв юм байна.

Ер нь би дотроо бодож байгаа бодол энэ 2-ыг ингээд хот болгоод явуулчихвал 2028 оны орон нутгийн сонгуулиар хамгийн цаад талын хугацаа дүүргийн ИТХ-ын сонгууль болох гэхээр зэрэг дүүргийг нь аль цагийг нь татан буулгаад, юу хот болгочихсон учраас хотын зөвлөл, хотын захирагчийг наана нь сонгочихсон байна. Дүүргийн хурлыг сонгохгүй гэнэ. Гэтэл дүүргийн хурлыг сонгохгүй гэхээр зэрэг дүүргийн нэг иргэн энэ асуудал Монгол Улсын Үндсэн хууль зөрччихлөө. Үндсэн хуульд аймаг, нийслэл, аймаг нь сум, нийслэл нь дүүрэгт хуваагдана л гэж заасан. Тэрнээс хотод хуваагдана гэж заагаагүй. Тийм учраас дүүргийн хуралтай байх ёстой гэдэг ийм зарга үүсээд, Үндсэн хуулийн зөрчил болж харагдах юм байна лээ. Тийм учраас би зүгээр шууд хэлэлцээд л явсан нь дээр. Ажлын хэсэг байгуулаад хэрэггүй.

**Б.Жавхлан:** Батжаргал гишүүн горимын санал гаргаж байна. Горимын саналд саяын дурдсан ажлын хэсгийг байгуулах шаардлагагүй юм байна. Шууд хэлэлцэх эсэхээ Их Хурал руу оруулаад, тэгээд Их Хурал дээр яаж шийднэ тэгээд цаашаа явъя гэсэн ийм зарчмын санал байна, горимын санал байна. Горимын дагуу санал хураалт. Байгуулъя гэхихсэн байна шүү дээ. Анхааралтай байгаарай л гээд байгаа нь тэр. Энхбаяр гишүүн горимын санал гаргая гэж байна.

**Б.Энхбаяр:** Сая санал хураалтад энэ техникийн саатал гараад болсонгүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна.

**Б.Жавхлан:** Энхбаяр гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн зөвшөөрч, 52.9 хувиар саяын санал хураалт хүчингүй боллоо. Батжаргал гишүүний гаргасан горимын саналаар дурдсан ажлын хэсэг байгуулах шаардлагагүй гэж саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар Батжаргал гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

15.40 цаг

### ***Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/***

Дараагийн асуудал мөн ажлын хэсэг байгаа. 6.Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. УИХ-ын гишүүн Очирбатын Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026 оны 5 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тогтоолын төслийг боловсруулсан байгаа.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол УИХ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24

дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн ТББХ-ноос тогтоох нь:

1.Очирбатын Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026 оны 5 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Зулпхар УИХ-ын гишүүн, гишүүдэд Ариунзаяа, Хэрлэн, Пүрэвдорж, Баатархүү. Гишүүд, ажлын хэсгийн гишүүдийг дахиж уншъя. Ариунзаяа, Батбаатар, Пүрэвдорж, Хэрлэн ийм 5 гишүүний бүрэлдэхүүнтэй. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. ТББХ-ны дарга Жавхлан гэсэн байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд анхааралтай байгаарай.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалт. Санал хураалтад 17 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар уг тогтоолын төсөл батлагдлаа.

15.44 цаг

***Тав.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайлан***

Дараагийн асуудалдаа оръё. 7.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг хэлэлцэж эхэлье. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг Ёс зүйн хорооны дарга Цэнддаваагийн Амартөгс танилцуулна. Амартөгс хэдэн номерын микрофон бэ, 5 уу? 5 номерын, ажлын хэсгийн 5 номерын микрофон. Энэ ажлын хэсгийг танилцуулахгүй юм уу?

Ажлын хэсгийг танилцуулна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайлан. Дараах ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна. Цэнддаваагийн Амартөгс Ёс зүйн хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн /ТАЗ/ гишүүн, Лхагвын Цэдэвсүрэн Ёс зүйн хорооны гишүүн, ТАЗ-ийн гишүүн, Лхагвасүрэнгийн Золзаяа Ёс зүйн хорооны гишүүн, ТАЗ-ийн гишүүн, Баярын Пүрэвдагва Ёс зүйн хорооны гишүүн, ТАЗ-ийн гишүүн, Бадамдоржийн Төгсцэнгэл Ёс зүйн хорооны гишүүн, ТАЗ-ийн гишүүн, Шайрын Батсүх Ёс зүйн хорооны гишүүн, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн, Доржсүрэнгийн Дуламсүрэн Ёс зүйн хорооны гишүүн, АТГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх хэлтсийн албаны дарга, Минжүүрийн Цэрэнбат Ёс зүйн хорооны гишүүн, АШУҮИС-ийн багш, Чогдонгийн Эрдэнэчимэг Ёс зүйн хорооны гишүүн, Удирдлагын

академийн багш, Намдагийн Ганбаатар Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга, Бямбаагийн Нарангарав Ёс зүйн хорооны Ажлын албаны Захиргаа, эрх зүйн хэлтсийн дарга, Сувдаагийн Батнасан Ёс зүйн хорооны Ажлын албаны Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн дарга. Ийм ажлын хэсэг ирсэн байна. Амартөгс даргын микрофоныг нээе. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

**Ц.Амартөгс:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. УИХ-ын ТББХ-ны хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилтыг бид хэрэгжүүлж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасныг үндэслэн Ёс зүйн хороо төрийн байгууллагуудын дэргэд дэд хороод байгуулагдан 24 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Монгол УИХ-ын тухай хууль, Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хууль, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын 25 оны дүнг танилцуулж байна. Энэхүү тайлан товхимол хэлбэрээр болон цахим байдлаар дэлгэрэнгүй тараагдсан учраас би товч үр дүнг танилцуулъя.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль нь анхдагч хууль, суурь хуулийг хэрэгжүүлэх зорилгоор энэ Ёс зүйн хороо, дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан, төрийн албан хаагчид хэрэгжүүлж байгаа. Нийт 230 гаруй мянган төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага зэрэг нийтийн албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарч байгаа. 2025 онд ЗГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороо төрийн болон нутгийн захиргааны байгууллагын дэргэдэх 2759 дэд хороонд 11861 төрийн албан хаагч ёс зүйн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан. Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд 77.1 хувь нь эмэгтэй, 87 хувь нь гүйцэтгэх албан тушаалтнууд ажиллаж байгаа. Энэхүү дэд хороонд хамт олны саналаар сонгогдох журмаар ажил үүргийг гүйцэтгэдэг.

Ёс зүйн дэд хороод нь хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд салбар нэгжийн хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэхээс гадна хэм хэмжээг сахиулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа. Бид Ёс зүйн хорооны зүгээс төрийн албанд ёс зүйн дэд бүтэц, институцийг бий болгох, ёс зүйн сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг тогтолцооны хувьд бэхжүүлэх, хяналт, хариуцлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Хууль хөтөлбөрт заасны дагуу бид 25 оноос 28 оныг хүртэлх стратеги төлөвлөгөөг батлан, хууль тогтоомжийн дагуу 12 дүрэм, журам, зааврыг, аргачлалыг боловсруулж, сургалт, судалгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж байна.

Ёс зүйн бие даасан тогтолцооны хүрээнд дэд хороодын хэрэгжүүлэх үйл ажиллагааг 5 үндсэн алхмаар хийгдэж байгаа. Энэхүү 5 алхмыг урьдчилан сэргийлэх, сургаж соён гэгээрүүлэх, судалж шинжлэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргаж, хариу арга хэмжээ авах зэргээр үйл ажиллагааны цогц байдлаар хангах системчилсэн арга зүйг тодорхойлсон. Ингэж тодорхойлсноор ёс зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдэж,

төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны хүртээмж, үр өгөөжид эергээр нөлөөлнө гэж бид тооцсон.

Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ажлын байран дахь ёс зүйн сургалтыг 84 байгууллагад зохион байгуулж, нийт 16.4 мянган албан хаагчийг танхим болон цахим хэлбэрээр хамрууллаа. Нийт ёс зүйн дэд хороодын түвшинд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 348.1 мянган албан хаагчид давхардсан тоогоор хамрагдсан нь өнгөрсөн оноос 57.6 хувиар өссөн байна. Төрийн албан хаагчийг сургаж хөгжүүлэх бодлогын уялдааг ханган, Удирдлагын академийн багш, судлаачид, эрдэмтдийн оролцоотойгоор сургалтын агуулга, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, 100 сургагч багшийг бэлтгэн дэд хороодын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүний нөөцийг бүрдүүллээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн нөлөөллийн аяныг 11 дүгээр сард зохион байгуулан "Хүндэлье, Энэрье" уриан доор зохион байгуулсан. Үүнд сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг түлхүү зохион байгуулсан байгаа. 2025 онд бид бүсчилсэн хөгжил, төрийн албаны манлайлал зөвлөгөөн сумдад болон зохион байгуулах болон сумдад ажилласан ажлын хэсэгт хамтарсан бүрэлдэхүүнээр ажиллаж, ёс зүйн хууль тогтоомжийн хүрээнд сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 6 бүс болон нийслэлд нийт 3.9 мянган албан хаагчдыг хамруулан энэхүү хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарч байгаа тулгамдсан асуудлуудын талаар хэлэлцсэн. ТАЗ, ЗГХЭГ-тай хамтран ажлын хэсэг байгуулан тодорхой энэ хэлэлцүүлгийн үед гарсан асуудлуудыг шийдвэрлэсний нэг нь төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээнд ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээг тооцдог болсон явдал болсон. Энэхүү ЗГ-аас баталсан үнэлгээний арга зүй, аргачлалд нийцүүлэн 3 багц үзүүлэлтээр бид 91 байгууллагын 3156 салбар нэгжийн мэдээллийг нэгтгэн тайланг дүгнэсэн.

Төрийн байгууллага дахь ёс зүйн дэд бүтэц, ёс зүйн манлайлал, хууль тогтоомжийн уялдааг хангасан байдлаар хэрхэн, яаж төлөвлөлт хийж, хэрэгжилт, хяналтыг зохион байгуулж байгаа вэ гэдгийг тодорхойлох эхний алхам болсон энэ нь. Улсын хэмжээнд энэхүү үнэлгээний дүн 63 хувьтай байна. Энэ нь төрийн албаны ёс зүйн тогтолцооны суурь тавигдсаныг харууллаа. Цаашид энэхүү үнэлгээг бид илүү бие даасан, хөндлөнгийн, мэргэжлийн түвшинд зохион байгуулж, өөрчлөлтийн бодитой хэмжүүр болгон боловсронгуй болгох зорилгоор олон улсын нийт жишигт нийцсэн төрийн албаны ёс зүйн индексийг тооцох аргачлалыг боловсруулж, нэвтрүүлэхээр ажиллаж байна. Олон улсын индекс тооцох аргачлал зарим улсуудын туршлагыг судаллаа. Төрийн албаны ёс зүйн индексийг нэвтрүүлснээр засаглалын чанар сайжирч, эрсдэлийг бууруулах, төрийн үйлчилгээний үр нөлөө нэмэгдэх, иргэдийн төрд итгэх итгэл бэхжих стратегийн ач холбогдолтой байдаг. Энэхүү үнэлгээ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулсан ажлаар бус, байгууллагын соёл, удирдлагын манлайлал, ил тод байдал, хариуцлага, шударга шийдвэр гаргалтын олон талт үзүүлэлтээр судлан тогтоох цогц ажиллагаа болно гэж үзэж байна.

Ёс зүйн хороо төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны суурь өгөгдөлд тулгуурлан системийг хөгжүүлж байгаа. Энэхүү системд бүртгэлтэй байгууллагуудын дэд хороодын үйл ажиллагааны хүрээнд 467 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн байна. Дэд систем нь гомдол, мэдээллийн бүртгэл хийх, ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, ёс зүйн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, эрсдэлийг тодорхойлох, статистик тайлан,

мэдээллийг шуурхай нэгтгэн боловсруулж бодлогод ашиглах нөхцөлийг бүрдүүлж байгаа. Системд бүртгэгдсэн мэдээллээр цахим түүх, лавлагаа үүсгэх төрийн бусад өгөгдлийн сан, системтэй мэдээлэл солилцох хөгжүүлэлтийг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдэлд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлалыг батлан, эрсдэлийн үнэлгээнд суурилан ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийг гаргах, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулах арга зүйг нэвтрүүлсэн. Энэ нь өөрөө байгууллагын ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, дотоод хяналт, ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх, албан хаагчдын ёс зүйн мэдлэг, харилцаа хандлагыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болсон гэж үзэж байгаа.

2025 оны байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн төлөв байдал, шалтгаан нөхцөлийг үнэлж үзсэн. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчлийн бүртгэлд 467 гомдол бүртгэгдсэн нь өмнөх үеэс 21.5 хувиар буурсан хэдий ч удирдах албан тушаалтантай холбоотой гомдлын мэдээлэл, гомдол, мэдээллийн тоо 80 гарсан. Ёс зүйн зөрчил гаргасан нийт албан хаагчдын 31.8 хувь нь өөрийн сайн дураар хариуцлагаа хүлээх энэ механизмд бүртгэгдсэн байна.

Ёс зүйн зөрчлийг агуулгаар нь ангилж үзвэл иргэдийн хүсэлтэд хариу өгөхгүй байна, хэл амаар доромжлох, мөн албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн зэрэг зөрчил бүртгэгдсэн 51.7 хувийг эзэлж байна. Ёс зүйн зөрчлийн шалтгааныг бид тандах судалгаагаар мөн судалж үзсэн. Ингэхэд иргэдээс үе хоорондын ялгаатай байдал, үйлчилгээний талаарх мэдээлэл хангалтгүй байгаа байдал, албан хаагчдын харилцаа хандлага нь төрийн үйлчилгээ авахад хүндрэл учруулж байна гэдэг энэ зүйлийг хэлж байгаа. Ёс зүйн зөрчил үүсэхэд хамгийн их нөлөөлж байгаа хүчин зүйлс удирдах ажилтны манлайлалгүй байдал, төрийн албан хаагчдын хүмүүжил, төлөвшил, хяналт, хариуцлагын механизм сул байна гэж дүгнэжээ. Тийм учраас бид энэ талыг, сул талыг арилгах арга хэмжээг бид зохион байгуулах шаардлагатай байгаа юм. Тайлант хугацаанд нийт зөрчлийн 46.6 хувь нь 10 жил хүртэл ажилласан албан хаагчид байгаа нь сургалт, мэргэшүүлэх үйл ажиллагааг илүү зохион байгуулах, үр дүнтэй ажиллагааг бий болгох шаардлагыг харуулж байгаа.

Ёс зүй, эрсдэлийн үнэлгээний дүнг бид харвал зөвхөн хууль тогтоомж болон мэргэжлийн үйл ажиллагааны мэдлэг, мэдээллээс гадна тухайн хувь хүний төлөвшил, мөн сэтгэл, сэтгэл зүйн ачаалал болон ажлын орчин, нийгмийн баталгаа, харилцаа хандлагын төлөв байдал зэрэг олон хүчин зүйлээс үүсэж байгаа гэдгийг судалгаанууд илтгэж байгаа. Тийм учраас төрийн албан хаагчийн ёс зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагааг түлхүү зохион байгуулсан.../минут дуусав/

**Б.Жавхлан:** Дуусаагүй биз дээ, микрофоныг өгье. Сая хэдэн минут дээр тавьчихсан байсан юм бэ? 10 минутаар нэмж сунгаж байна шүү. 10 минутдаа багтаагаарай.

**Ц.Амартөгс:** Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж маань өөрөө төрийн албаны үйл ажиллагааны шударга байдал, ил тод, хариуцлагатай байдлыг төлөвшүүлэхэд суурь нөхцөлийг бүрдүүлж байгаа. Тийм учраас сая дурдсан энэ

асуудлуудыг шийдвэрлэхэд илүү бодитой эерэг үр нөлөөг бид соён гэгээрүүлэх, сургах үйл ажиллагаагаар зохион байгуулна.

Ёс зүйн төлөв байдал засаглалыг, дэд бүтцийг бэхжүүлэхэд бид тодорхой ахиц гаргалаа гэж үзэж байгаа. Түрүүн дурдсан ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээг хийсэн нь энэхүү хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нэгдсэн хяналтын суурийг бий болгосон. Гэхдээ байгууллагуудын дэргэдэх дэд хороод тодорхой хэмжээнд 78 хувьтай үйл ажиллагааны түвшин үнэлэгдсэн нь эхлээд 2 жил болж байгаа энэ үйл ажиллагааг хангалттай түвшинд суурь бүрдлээ гэж ингэж үзэж байна. Тийм учраас энэхүү дэд хороодын үйл ажиллагааг илүү бодитой хэрэгжүүлж, үр дүнг гаргахад шаардлагатай тодорхой хэмжээний үйл ажиллагаа, арга хэмжээг байгууллагын удирдлагын зүгээс тодорхойлох, мөн төсөв, үйл ажиллагаанд нь шаардлагатай дэмжлэгийн механизмыг илүү өргөжүүлэх шаардлагатай байгаа нь харагдсан.

Төрийн албан хаагчдын хэдийгээр энэхүү дэд хороодын үйл ажиллагаа нь эерэг үр дүн авчирч байгаа боловч удирдлагын ёс зүйн манлайлал, байгууллагын соёл, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо сул хэвээр байна гэж бид дүгнэж байна. Төрийн албан хаагчдын энэхүү сэтгэл ханамж, нийгмийн баталгааг сайжруулах, дэд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үүний зэрэгцээ салбарын хууль тогтоомж болон мэргэжлийн ёс зүйн дүрмийн хоорондын уялдаагүй байдал, хийдэлтэй болон зөрчилтэй гэж үзэх, эсхүл ялгаатай байдал нь нарийн зохицуулагдаагүй байгаа зүйлүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлтөд хийх замаар уялдааг хангах шаардлагатай байна. Тухайлбал нийт салбар, мэргэжлийн онцлогийг харгалзсан тусгайлан тогтоосон 33 байгууллагын 44 ёс зүйн хэм хэмжээ, дүрэм, журмууд өнөөдөр байгаа. Энийг уялдааг хангах шаардлага байгаа юм.

Үүний зэрэгцээ бид үйл ажиллагааны түвшинд тодорхой хэдэн алхмыг авч хэрэгжүүлэх шаардлага байна гэж үзсэн. Түрүүн дурдсан ёс зүй, сахилга, хариуцлагын үнэлгээг илүү бодитой өргөн хүрээнд хийж хэвших, ёс зүйн олон улсын индексийг нэвтрүүлэх, томилох эрх бүхий албан тушаалтан болон удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх, ёс зүйн манлайллын шалгуур үзүүлэлтийг бид гаргах ийм үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт байгаа. Тэгэхээр энийг хэрэгжүүлэх зорилтыг илүү чухалчлан авч үзэх ёстой юм гэж үзэж байна.

Мөн цахим системийн хөгжүүлэлтийг илүү сайжруулан бид цахим түүхийг бүтээж И-Монголиа /E-Mongolia/ зэрэг цахим лавлагаа, үйлчилгээний системээс лавлагаа, ёс зүйн лавлагаа авах ийм боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хуульд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх, ёс зүй, харилцаа хандлага, соёлыг дээшлүүлэхэд Ёс зүйн хороодын үйл ажиллагаа чухал үүрэгтэй байгааг дахин энд онцлон хэлье. Улсын хэмжээнд ёс зүй, ёс зүйн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зөвхөн төрийн албан хаагчдад чиглүүлэн зохион байгуулахаас гадна нийт нийгэмд чиглэсэн, ялангуяа хүүхэд, өсвөр үе, залуучуудад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг өргөжүүлэн зохион байгуулж, сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай анхдагч хууль батлагдан гарсан нь төрийн албан хаагчдад тодорхой эерэг өөрчлөлт бий болгох суурь боллоо. Тийм учраас энэхүү механизмыг илүү үр дүнтэй, бодитой хэрэгжүүлэх тууштай бодлогын залгамж халаатай, харилцсан уялдаатай ийм үйл ажиллагаанууд цаашдаа

өргөжүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж бид үзэж үйл ажиллагаагаа төлөвлөн зохион байгуулж байна. Танилцуулж дууслаа.

**Б.Жавхлан:** Амартөгс даргад баярлалаа. Ёс зүйн хорооны тайлангийн талаар асуулт асуух гишүүд байна уу? Үгээ цуг явчих уу? Асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Энэ дэлгэцээ өгөөрэй. Зулпхар гишүүнээр тасаллаа. Лувсаннъямын Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

**Л.Гантөмөр:** Ёс зүйн хорооны тайлан сонсож байна. Ёс зүйн код хийгээд бид энэ төрийн албыг илүү мэргэшүүлэх зорилго тавиад ажиллаж байгаа нь үнэхээр нүдээ олсон зөв байгаа юм. Хамгийн гол нь манайхан ингээд тодорхой асуудлыг ярихаар нэг тийм урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх гэдэг дээрээ гол анхаарлаа тавиад, ёс зүйн зөрчилтэйгөө хэрхэн тэмцэх вэ гэдэг шууд утгаараа тэмцэх тэмцэл дээрээ ер нь хойшоо суугаад байдаг юм. Жишээлбэл Авлигын газар авлигаас урьдчилан сэргийлэх гээд л ажил хийгээд байдаг яг авлигачаа очиж барьдаггүй. Тэгээд уг нь өнгөрсөн парламентын хийсэн их сайн зүйл энэ ёс зүйн асуудал. Дээр нь энэ Ашиг сонирхлын зөрчлийн хуулиар Их Хурлын гишүүдийг, сайд нарыг казинод тоглохыг хориглосон, хамаарал бүхий этгээдээрээ тендер авахыг хориглосон. Гэтэл энэ хуулийн заалтуудын хэрэгжилт хангагдахгүй байгаад байгаа юм.

Тэгээд миний асуулт та бүхэн гадаадын казинод тоглож байгаа төрийн албан хаагчдын тухай мэдээллийг авч байгаа юу? Би шулуухан л 1 дүгээрт тэрийг асуумаар байгаа юм. 2 дугаарт энэ цахим мөрийтэй тоглоод байгаа хүмүүсийг мөрийтэй тоглоомоос холдуулах ажлыг хэрхэн зохион байгуулах вэ гэдэг ийм санал санаачилга байна уу? Энэ чинь ерөөсөө цахим мөрийтэй тоглоом бол Монгол төрийн гамшиг боллоо шүү дээ. Бүгдээрээ хоорондоо ч тоглож байдаг, цахим мөрийтэй тоглоомыг гадна дотнын сайтууд руу ороод бөөн бөөнөөрөө мөнгө алдаж байдаг. Тэгээд энэ 2 зүйл дээр онцгой анхаарах боломж, бололцооны тухай дарга маань Цэдэвсүрэн дарга энэ дээр их тодорхой гаргалгаа гаргаж, ТББХ-тойгоо хамтарч тэмцэхгүй бол ингээд мөрийтэй тоглоомд живлээ.

Үнэндээ АТГ маань энэ мөрийтэй тоглоомыг гадаадад казинод тоглож байгаа төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчдын тухай мэдээлэл авч байна уу, үгүй юу? Яг үнэндээ жирийн албан хаагчид гадаадад очоод казинод тоглох нь багаслаа гээд Элчин сайдын яам /ЭСЯ/-нууд их аятайхан юм хэлээд байгаа шүү дээ. Өмнө нь бөөнөөрөө очоод 5 хоногийн сургалтын 4-д нь казинод тоглодог байсан бол одоо ер нь сургалтыг хоёрхон хоногт хийгээд харьдаг болсон шүү манайхан гэж хэлж байгаа. Хийх юм байхгүй яг сургалтдаа суугаад ингээд буцдаг болсон. Тэгээд энэ их давуу тал. Гэтэл нөгөө талд нь энэ цахим гар утаснаасаа мөрийтэй тоглоод байдаг асуудал. Энэ асуудал дээр их тодорхой шийдэл гаргаж өгөөч гэж асууж байна 1.

2 дугаарт, энэ архидан согтуурах гэдэг асуудал байгаа төрийн албанд, зангиатай архичид. Тэгээд энэний тод илрэл болохоор аймгууд руу ордог гардаг дээр нэг ийм цэнхэр дугаартай машинууд зогсож байгаад л нэгнийгээ үдэж гаргаж байна гээд архи задлаад зогсож байгаа нь илт ард түмэнд харагдаад байгаа юм. Тэгээд энэ балиар зуршлаас бид салахгүй юм уу. Тэгээд та бүхэн эдийн засгийн, ёс зүйн код ярихдаа энэ гаргадаг угтдагийг болиулахгүй юм уу? Тэгээд тэнд очоод энэ нэг Монгол ёс гээд худлаа ярьцаагаад, Монгол хүн хэзээ байтал нэгнийгээ явуулахад нэг архи, дарс гээд л тийм юм байхгүй шүү дээ. Тэгээд бидний сүүлийн

олон жилийн тийм дадал болчхоод байгаа энэ балиар юмнаас салах арга байна уу?  
Нэг ийм 2 зүйлийг мөрийтэй тоглоом.../минут дуусав/

**Б.Жавхлан:** Хариулт, 5 номерын микрофон Амартөгс дарга.

**Ц.Амартөгс:** Гантөмөр гишүүний асуултад хариулъя. Юуны өмнө архидан согтуурсантай холбоотой хуулийн заалтыг хэрхэн, яаж хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийг өгье. Тэгэхээр энэ Ёс зүйн тухай хуулийн 8.2.8-д энэ ёс зүйн зөрчил юм гэсэн байдлаар тодорхойлоод өгчихсөн учраас бид энэнтэй холбоотой гарсан гомдол болон баримт, мэдээллүүдийг бүгдийг нь хянан шийдвэрлэж хариуцлага тооцож байгаа. Тухайлбал өнгөрсөн онд 21 ийм зөрчил бүртгэгдэж, хариуцлага тооцсон ийм мэдээлэл гарч байна. Цаашдаа ч гэсэн албан томилолтоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа албан хаагчдыг угтах, үдэх ийм үйл ажиллагааг архи, дарстай зохион байгуулах ч гэдэг юм уу, томилолтоор ажиллах үедээ архидан согтуурсан үйл ажиллагаа нь ажил үүргээ хэрэгжүүлэхдээ энэ зориулалтыг зөрчиж байна гэж үзэх бүртгэл, мэдээллийг хийж, хэрэгжүүлж зөвлөн туслах гэдэг юм уу сургалтынхаа гол кэйсүүдийг хийж ажиллана.

Цахим мөрийтэй тоглоом, казино тоглож байгаа мэдээллийг гадаад улсаас авч байгаа өнөөдрийн тохиолдол яг Ёс зүйн хороо дээр алга байна. Гадаад хэргийн яам болон дэд хороодод өгч байгаа мэдээлэл гадаад болон дотоод томилолтоор үйл ажиллагаа явж байхдаа хуулиар хориглосон үйл ажиллагаа хэрвээ хийж байгаа бол мэдээлэл гомдол энэ өгөх, шалгаж шийдвэрлэх ийм үйл ажиллагааг хийх ёстой гэдэг ийм мэдээллүүдийг өгч ажиллаж байна. Одоогоор яг бүртгэгдсэн энэ мэдээлэл албан ёсоор хуулиар энэ мэдээллийг авах үүрэг гэдэг юм уу, шууд Ёс зүйн хороонд алга байна. Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх явцад энийг бүртгэж шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

Цаашдаа ер нь төрийн алба, төрийн албан хаагч төрийн албаны үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ бусад хуулиар хориглосон үйл ажиллагааг огт хийхгүй байх, таслан зогсоох гэдэг энэ зарчмын үйл ажиллагаануудыг холбогдох байгууллагууд хамтарч ажиллая гэж байгаа маань хяналтын механизмыг илүү нэгдсэн зарчмаар хэрэгжүүлэх ийм бололцоог бүрдүүлэх боломжийг бий болгож ажиллана гэсэн ийм зорилготой ажиллаж байна.

**Б.Жавхлан:** Гантөмөр гишүүн асуулт тодруулъя. Микрофоныг нээнэ үү.

**Л.Гантөмөр:** Амартөгс дарга энэ ийм байгаа байхгүй юу. Монгол Улс Ёс зүйн хороо гэж байгаа юм. Тэгээд та бол тийм Гадаад харилцааны яамны царай харах албан тушаалтан биш байхгүй юу. Өөрөө шууд гадаад харилцаа хийж болно, өөрөө шууд Сингапурын авлигын газартай ажиллаж болно, ажилла. Шууд Солонгосын прокурортой та ажиллаж болно, шууд ажиллах хэрэгтэй, хуулиа харах хэрэгтэй. Бүрэн эрх нь та нарт байгаа би хэлж байна шүү дээ. Өмнөх Их Хурлын хийсэн хамгийн сайн ажил энэ шүү, харамсалтай нь маш сайн зүйлийг хийчхээд ажил хэрэг болгохгүй байна шүү дээ. Тэгэхээр энэ төрийн албаныхныг цахим мөрийтэй тоглоом болоод гадаадад казино тоглодог зүйлийг таслан зогсоо 1 дүгээрт.

2 дугаарт бүх төрийн алба руу таны гарын үсэгтэй бичиг яваад л болоо байхгүй юу. Угтахаа боль, үдэхээ боль. Ажлын хэсэг, гадаад, дотоод.../минут дуусав/

**Б.Жавхлан:** Гантөмөр гишүүний нэмэлт микрофоны хугацаа, 1 минут.

**Л.Гантөмөр:** Баярлалаа. Тэгэхээр харин таны гарын үсэгтэй бүх төрийн албаны удирдлагуудад угтах, үдэх ажлаа зогсоо гэсэн бичиг явж болох уу? Надад их энгийн харагдаад байгаа юм. Тэгээд угтаж үдэж байгаа чинь өөрөө аймгийн хил дээр байдаг, ард түмэн харж байдаг, худлаа хэлсэн хүн дороо баригдана. Сумын ард түмэн мэдэж байгаа. Тэгэхээр энэ дээр нэг айхтар юм нь ингээд л нэг судалгааны баг, ажлын хэсэг, тэгээд л олон улсын төсөл, хөтөлбөр гээд энгийн хүмүүс дагуулаад оччихсон юм шиг мөртөө яг төрийн албан хаагчдыг ороод ингээд буруу ёс зүйн зөрчил гаргуулах ажил хийгээд байгаа байхгүй юу даа. Тийм учраас би танаас дараа жилийн тайлан дээрээ та би Макаотой ажиллаж байгаа, Сингапуртай ажиллаж байгаа, Солонгосын казиног мэдэж байгаа, тэр прокурортой ажиллаж байгаа, дээр нь энэ вэб хуудаснуудыг хаах асуудлыг би прокурорт тавьж байгаа, АТГ-тай ажиллаж байгаа, кибер аюулгүй байдалтай ажиллаж байгаа, төрийн албаныхан дээр 92 00 гэсэн.../минут дуусав/

**Б.Жавхлан:** 5 уу, нэмэлт тодруулга өгөөрэй. 5 номерын микрофон ажлын хэсгийн.

**Ц.Амартөгс:** Тодорхой арга хэмжээ авч, үйл ажиллагаа зохион байгуулан, Төрийн албаны хуульд заасан ёс зүйн нийтлэг шаардлага, хориглох зүйлийг хэрэгжүүлж ажиллах талаар дэд хороодод, байгууллагын дэд хороодоор дамжуулаад энэ үйл ажиллагааг зохион байгуулъя. Тэгээд энэний гарсан үр дүн болон шалган шийдвэрлэх мэдээллийг төрийн байгууллагын дэд хороод нь өөрсдөө хянан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх ийм механизмыг бүрдүүлж ажиллая.

**Б.Жавхлан:** Гантөмөр гишүүн амжилт хүсье гэж байна шүү танд. Аюушийн Ариунзаяа гишүүний микрофоныг өгье. Асуулт, үг цуг шүү.

**А.Ариунзаяа:** Юуны өмнө та бүхнээсээ 5 цаг хүлээлгэсэнд уучлалт хүсмээр байна. Ямар их ажил алдаж, ямар удаан хүлээж байгаа бол. ТББХ 11 цагаас хуралдах ёстой байсан тэгээд сая 15 цаг орчимд ирц арай гэж бүрдэж, хурлаа хийлээ. Гэсэн ч бид УИХ-ын багц хуулиудаараа гишүүдийн ёс зүйн асуудлыг цэгцлэх ийм хууль, ийм төслүүдийг ярьж байхад дахиад л мэтгэлцээн, маргаан үүсээд л сандал, суудлын асуудал яриад л дахиад л тэрнийгээ хэлэлцэж чадахгүй ингээд хойшлуулчихлаа. Ер нь ёс зүйн өндөрлөгөө өөрсдөө хадгалсан хүмүүс өөрөөсөө, өөрсдөө ёс зүйтэй байж байж бусдаас ёс зүй нэхдэг. Тэгээд өөрөөсөө нэхээгүй ёс зүйгээ бусдаас нэхэх нь өөрөө эргээд нөгөө дахиад л нөгөө ёс зүйгүй асуудал гэдэг шиг. Тэгээд УИХ, УИХ-ын гишүүд өөрсдөө ёс зүйгүй байж, төрийн албан хаагчдын ёс зүйтэй байдлын энэ тайланг нь хэлэлцээд суух нь үнэхээрийн ичгэвтэр асуудал юм.

Та бүхний энэ дүгнэлт дотор яах вэ нийгэмд хэлэхгүй ч гэсэн төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллын шалгуур үзүүлэлтийг бий болгож, хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна гэж бичсэн байна. Баярлалаа, зөв. УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэм, хуулийн зохицуулалтын уялдааг хангах, төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн хамрах хүрээ, зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох зэргийг оруулсан байна, зөв. Үнэхээрийн УИХ-ын гишүүд бид өнөөдөр ёс зүйтэй байх хэрэгтэй байна. Ямар сайндаа л Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ын гишүүдийн ёс зүйтэй холбоотой хууль өргөн барьж байх вэ дээ. Би тухайн үедээ жагсаалтын гишүүдийг л онцолсон байна, ер нь бүр эгүүлэн

татахаар санал оруулсан байна гээд тухайн үедээ эсэргүүцэж байсан. Тэгээд УИХ яах вэ хүлээгээд авчихсан, хэлэлцэж эхлээгүй байна.

УИХ-ын гишүүд өөрсдөө хууль санаачилж, өөрсдийнхөө ёс зүйгээ, сахилга хариуцлагаа дээшлүүлэе гээд яг одоо хууль хэлэлцэж байна. Ерөнхийлөгч шиг хуралдааныхаа 30 хувьд нь биечлэн оролцоогүй, санал хураалтынхаа 30 хувьд нь оролцоогүй байвал эгүүлэн татах гээгүй ч гэсэн хуулийн төсөлдөө бид юу оруулсан бэ гэхээр хуралдааныхаа 50 хувьд нь оролцоогүй бол таны тухайн сарын үйл ажиллагааны зардлыг олгохгүй. Албан ёсоор товд тавигдаж байгаа хуралдаан, чуулган дан ганц гэлтгүй Байнгын хороо, ажлын хэсгийн хуралдаанд оролцоогүй бол тухайн өдрийн чинь цалинг олгохгүй гэж зааж оруулж өгсөн. Харамсалтай нь ажлын хэсэг энэ үйл ажиллагааны зардлыг хасахгүй байх ийм саналыг оруулаад ирэх шиг болсон. Сая тэгэхдээ бид хамгаалаад үлдлээ. Та 50-аас дээш хувьд нь ажлаа хийгээгүй бол үйл ажиллагаа гэж юу байх вэ дээ зардлыг чинь хасах чинь зөв. Ийм учраас хариуцлагатай бай.

УИХ-ын тухай хуулийн 41.2, 44.1.11-д УИХ-ын гишүүн бусдыг гэмт хэрэгт гүтгэх, доромжлох хориотой. Тэгээд энэ хориглосон зүйл, заалтыг зөрчвөл иргэний маргааны журмаар шүүхэд хандаж болно гэж заалт оруулсан байсан. Үүнийг ажлын хэсгийн хүрээнд хасах ийм санал оруулчихсан байх шиг байна лээ. Угаасаа хориотой зүйлийг зөрчвөл та шүүхэд очих л болно доо. Тэгэхээр гишүүд өөрсдөө бусдыг гүтгэж, доромжилж ёс зүйгүй байвал яаж бусдаас энэ ёс зүйг нь нэхэх гээд байгаа юм бэ? Та нарт ч гэсэн ажлаа хийхэд хүнд байдаг байлгүй дээ. Энэ гишүүдээ хараач, юу би яаж ёс зүйтэй байх юм гэж. Тэгэхээр юу хэлэх вэ дээ. Тайланг нь сонслоо. УИХ-ын гишүүдээ л ёс зүйтэй бай гэж уриалъя даа.

**Б.Жавхлан:** Ариунзаяа гишүүн үг хэллээ, баярлалаа. Сархадын Зулпхар гишүүнд микрофон өгье.

**С.Зулпхар:** Та бүхний амар амгаланг айлтгая. Ёс зүйн хорооны тайлан сонсож байна. Бид үндсэндээ 2 дахь удаагаа сонсож байна. Өнгөрсөн жил тайлан сонссон, зохих түвшний асуулт, саналууд өгч байсан. Тодорхой чиглэлээр хийсэн ажлуудын үр дүн ер нь тулгамдаж байгаа сорилтуудыг яаж шийдэх вэ гэдэг чиглэлээр санал солилцож байсан санагдаж байна. Эхлээд 2 асуулт байна. Тэгээд өнгөрсөн бидэнд тайлан танилцуулах үеэр нэг зүйл их тодорхой яригдаж байсан. Ёс зүйн дэд хороод яг ингээд ажиллах болохоор зэрэг ёс зүйн дэд хороодын нэн ялангуяа хариуцлага тооцохтой холбоотой тэр зохион байгуулалт болон шийдвэр гаргахтай уялдсан зарим механизм өөрөө ажиллахгүй байна гэсэн нэг ийм зүйлийг та бүхэнд танилцуулж байсан. Тэгээд эндээс чиглэл гарч л байсан л даа. Та бүхэн Ёс зүйн дэд хороодыг шаардлагатай үед нь хариуцлагыг нь тооцдог тэр механизмыг үйлчлүүлэх ёстой. Тэгээд тэрийгээ та бүхэн өөрсдөө сайн туршлагаар нь бодож олох ёстой байх, нэг бол сайн туршлыг нэгээс нөгөөд дамжуулж болно гэсэн ийм л зүйл өгч байсан яригдаж байсан, сайн санаж байна. Тэгэхээр энэ чиглэлээр ямаршуу үр дүн гарч байна гэсэн нэг ийм асуулт байгаа.

2 дахь зүйл Их Хурал дээр ингээд бид өнгөрсөн хавраас хойш нэг ийм хавраас 2 сараас хойш нэг ийм маргаан мэтгэлцээн явж байна л даа. Их Хурал өөрөө угаасаа мэтгэлцээний талбар учраас тийм мэтгэлцээн байгаа нь сайн. Ёс зүйг хуульчилж болно, болохгүй гэсэн ийм маргаан яваад байгаа байхгүй юу. Гэхдээ бид Төрийн албан хаагчийн ёс зүйн хуультай, Ёс зүйн тухай хуультай анхдагч хууль. Яг энийгээ дагасан үндэсний хэмжээний тогтолцоо бий болчихсон одоо зохих түвшинд

ажиллаж байна. Тэгэхээр яг өнөөдөр Ариунзаяа гишүүн ч гэсэн сая хэлж байна. УИХ-ын тухай болон УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр төрийн албан хаагчдын, улс төрийн албан хаагчдын үүн дотор УИХ-ын гишүүдийн ёс зүйн тодорхой харилцаануудыг зохицуулах ийм зохицуулалт орж ирж байгаа юм. Өөрөө хуульчилж байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ дээр та бүхэн хорооны гишүүд маань ямар байр суурьтай байдаг вэ? Энэ ёс зүйг хуульчлах ёстой юм уу, хуульчлах ёсгүй юм уу гэдэг дээр та бүхэн угаасаа тодорхой байр суурьтай байж байгаа гэдэгт эргэлзэшгүй байна. Энэ дээр та бүхэн нэг хариулт өгөөч гэж?

**Б.Жавхлан:** Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 номер.

**Ц.Амартөгс:** Зулпхар гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн жилийн тайланд ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг хэтэрхий жижиглэсэн гэдэг юм уу, зохион байгуулалтгүй байгуулах вий дээ гэдэг ийм болгоомжлол, зөвлөмжийг өгч байсан. Тэгэхээр энэ жил бид зохион байгуулалтыг харьяалах байгууллагууд, харьяалах дээд шатны байгууллагууддаа бодлогын хувьд зангидагддаг байх. Энэ утгаараа 91 байгууллагын толгой гэх юм уу, байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн зөвлөмж, арга зүйгээр хангаад, байгууллага болгон дээр байгаа салбарын онцлогоо хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр бидний ирсэн гомдлыг шийдвэрлэлтийн байдал дээр тодорхой ахиц гарсан гэж үзэж байгаа. Нийт 520 гомдол гарснаас 467 нь манай хуульд хамаарч байна гэж үзэхэд 195 нь зөрчил мөн байна гэдэг ийм дүгнэлт гараад, энэ дүгнэлтийн дагуу бүгд арга хэмжээ авсан байна. Хариуцлага ногдуулсан байна. Ингэхдээ сайн дураараа мөн захиргааны шийдвэрээр гэсэн энэ хариуцлагуудыг ногдуулсан. Мэдээж дийлэнх нь сануулах, ганцаарчлан сануулах, уучлалт гуйлгах ийм хариуцлагын хэлбэрүүдийг сонгож ажилласан байна. Тухайн ёс зүйн дэд хороонд ажиллаж байгаа гишүүний хэрвээ асуудал гарч байгаа бол тэр нь харьяалах дээд шатны байгууллагын дэд хороондоо гомдлыг нь өгч шийдвэрлүүлэх ийм зарчмаар бие биеийг нь харьяалан удирдах ийм хэрэгжилтийг хангах зохион байгуулалт хийж ажилласан.

Ёс зүйг хуульчлах эсэхтэй холбоотой асуудал мөн энэ хуулийг батлагдаж байх явцад гарсан. Гэхдээ бид энэ хуульчлагдсан байгаа ёс зүйн асуудал нь мэргэжлийн буюу төрийн албаны үйл ажиллагаанд баримтлах хэм хэмжээг хуульчлан буюу нэг жигд нийтлэг байдлаар сахин мөрдүүлэх ийм зорилготой гарсан гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас мэргэжлийн салбарын хүрээнд буюу төрийн албаны үйл ажиллагаанд баримталж байгаа нийтлэг хэм хэмжээ, суурь зохицуулалт гэж үзээд, энэ төрийн албанд үйл ажиллагаа явуулж байгаа 4300 байгууллага болон нийт 230 гаруй албан хаагчид суурь байдлаар энэ зохицуулалтыг мөрдөх, дээрээс нь мэргэжлийн онцлог зохицуулалтуудыг нэмж мөрдөх ийм үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай үйл ажиллагаагаа явуулж байна.

**Б.Жавхлан:** Зулпхар гишүүн тодруулъя.

**С.Зулпхар:** Түрүүн Гантөмөр гишүүн их тийм чухал юм асуусан. Гантөмөр гишүүн ингэж байна шүү дээ тодорхой нийгмийн харилцаанд бий болж байгаа тодорхой асуудал нь төрийн албан хаагчид тэрийг ямар нэгэн зан үйл юм уу, үйлдэл болгож байгаа бол тэрийг хэрвээ ёс зүй зөрчсөн гэж үзвэл тэрийг зохицуулаач гэж байгаа юм. Тэрийг заавал хуулиар гэхгүйгээр хэлж байна шүү дээ та бичиг явуулаад л, тэгээд л жишээ нь тэр орон нутагт энийг биелүүлэх ёстой. Үндэсний хэмжээнд жишээ нь Ёс зүйн хороо энэ эрх нь байж байгаа гэж байгаа юм.

2 дахь зүйлтэй холбогдуулж би зориуд асууж байгаа нь өнөөдөр бидний энэ хэлэлцэх гээд хэлэлцэж амжаагүй хууль байгаад байна л даа. Яах вэ Байнгын хороогоор шүү дээ, ажлын хэсгээр гарчихсан. Тэрэн дээр тодорхой зүйлүүдийг УИХ-ын гишүүний өөрийнх нь хүлээсэн чиг үүргийг хуульчилж байгаа юм. Хуралдаандаа суухгүй яах юм гэдэг юм. Биечлэн саналаа өгч чадахгүй яах юм. Гэхдээ тэр чинь тоотой шүү дээ энэ чинь, энийг хуульчлахгүй бол болохгүй байна гэдэг асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр.../минут дуусав/

**Б.Жавхлан:** 1 минут нэмж өгье.

**С.Зулпхар:** Тэгэхээр та бүхэн тэр хуулийн төслийг угаасаа байж байгаа шүү дээ d.parliament.mn дээр байж байгаа. Энийг та бүхэн хараад бидэнд саналаа хэлж баймаар юм шиг байгаа юм. Хэлэх ч ёстой. Өөрөөр хэлбэл тэрийг чинь хуульчлах ёстой бол. Тэртээ тэргүй бид угаасаа мэдэж байгаа шүү дээ. Философийнхоо талаас нь аваад үзвэл ёс зүйг хуульчилж болно гэдэг, бүгдийг нь хуульчилж болдоггүй. Хэзээ хуульчилж болдог вэ гэхээр зэрэг энэ өөрөө байгууллагын түвшинд юм уу, тодорхой институцийн түвшинд ямар нэгэн харилцаа, хэм хэмжээг зохицуулах болбол энийг хуульчилж болно, зарим тохиолдолд хуульчилдаггүй гээд. Энэ талаас нь та бүхэн бидний энэ мэтгэлцээнд мэргэжлийн талаас нь оролцооч гэж байгаа юм. Та бүхний үг бидэнд үнэтэй цэнтэй, мэргэжлийн улсууд энэ асуудлыг сайн хариуцсан улсууд учраас гэж байгаа юм. Тэгж байж нийгмээрээ бид саяын ярьсан бид ёс зүйтэй байх нь бидний үүрэг юм бол тэрийг зохих түвшинд хуульчилж болно гэдгийг бүгд ойлгодог. Тэгээд тэр хуулиа өнөөдөр ингээд сууж байгаад батлах ёстой л байсан гэж байгаа юм. Энийг та бүхэн хэлж дуулгах ёстой шүү гэж байгаа юм.

**Б.Жавхлан:** Гишүүнийх үг үү тийм ээ? Баярлалаа. Амартөгс даргаа ер нь нөгөө тооноос чанарт гэдэг шиг төрийн албан хаагчийг соён гэгээрүүлнэ гэдэг маань өргөдлийн тоо буурах, нэмэгдэх гэхээсээ илүүтэйгээр төрийн албаны нэр хүнд, иргэдийн төрд итгэх итгэл, итгэл үнэмшил, сэтгэл ханамж нэмэгдсэн үү, үгүй юү гэдгийг харж, энийг танай гол зорилго агуулга энийгээ яаж хэмжиж харж байна вэ? Тэрнээс биш тэдэн сургагч багш, тэдэн хүн хамрагдсан гэдэг энэ тоонууд 100 хувь хангалттай биш шүү дээ. Тэгэхээр төрийн албан хаагчийг соён гэгээрүүлснээр хуулийн хэрэгжилт сайжирсан. Гол нь төрийн албан хаагчийн хандлага, бүтээмж, гүйцэтгэл мэдэгдэхүйц, хэмжигдэхүйц нэмэгдсэн, ахисан үр дүн гарсан байх ёстой. Та энэ талаар ер нь яаж харж байна вэ, яаж хэмжиж харж байна вэ? Энэ талаар нэг хэлээч, мэдээлэл өгөөч?

**Ц.Амартөгс:** Бид Ёс зүйн хороон дээрээ яг энэ үйл ажиллагаа шинэ тутам байгаа тогтолцоогоо хэрхэн, яаж зөв оновчтой бүрдүүлэх вэ гэдэг дээр хэлэлцэж ярилцдаг. Ингэхдээ олон улсын тэр ёс зүйн индекс гэж энэ хэмжүүр үзүүлэлтийг авчрах нь, оруулж ирж нэвтрүүлэх нь илүү бодитой хэмжүүр болох юм байна. Сэтгэл ханамжийн түвшин, төрийн албаны шударга байдлын түвшин, шийдвэр гаргалт, оролцоо, ил тод байдал гэдэг энэ олон талт хэмжүүр үзүүлэлтээр бид өөрчлөлтийг хэмжиж байж, зөвхөн нэг байгууллагын хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тооноос илүү бодитой өөрчлөлт, нийгмийн өөрчлөлтийг авчрах юм байна гэдэг ийм зүйл судлаад, тэгээд энэ онд бид ёс зүйн индексийг тооцоолох аргачлалыг боловсруулах үйл ажиллагаа дээрээ ажиллаж байгаа. Тэгээд туршин нэвтрүүлээд, үе шаттайгаар бид олон салбарын бусад үзүүлэлттэй уялдуулсан, зөвхөн нэг байгууллагын бус, илүү иргэн төрийн үйлчилгээ хүртээмжтэй авах, шударга шийдвэр гаргах, иргэний эрх ашгийг хамгаалах, мөн ёс зүйтэй хандлага, төлөвшилийг үнэлэх ийм боломжтой цогц үзүүлэлтийг нэвтрүүлнэ гэж харж байна.

**Б.Жавхлан:** Миний асуугаад байгаа нь яг төрийн албаны хаагчдынхаа талаас тэгээд харчхаж байна. Гол нь яг иргэд талаасаа ямар сэтгэл ханамж, яг төрд итгэх итгэл нь ямар болсон бэ, яаж сайжирсан бэ гэдгийг л бид энэ тайлангаас хармаар байгаа байхгүй юу. Тэгэхгүй ингээд яг төрийн албан хаагчид дээрээ нэг ийм хэмжилт хийчхээд л, тэгээд тэрийгээ ингээд тайлагнахаар чинь хангалтгүй байна л гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр дараагийнхаа тайлан дээр саяын гишүүдийн хэлсэн үг, асуултыг маш сайн ажил хэрэг болгоод, саяын миний мөн тодруулж хэлсэн тэр хэмжигдэхүйц үр дүнг гаргаж тайлагнаж байх ёстой шүү гэдгийг анхааруулж хэлье.

Гишүүд тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлж дууслаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсэгт баярлалаа.

16.25 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА